Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 59,221,992.1 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 888,329.8 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 621,830.9 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Байгаль орчин, аялал жуулчлалын яамны 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 11,932,303.1 мянган төгрөгөөр буюу 20.2 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан мөнгөн хөрөнгө, урьдчилж гарсан зардал, бараа материал, хуримтлагдсан үр дүнгийн данснууд байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/мянган төгрөг/
			Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	1.0	1,005,472.9	1,005,471.9
Авлага	1,118,838.9	377,287.8	(741,551.1)
Урьдчилж гарсан тооцоо	26,473,669.7	20,460,574.8	(6,013,094.9)
Бараа материал	902,944.1	13,937,036.3	13,034,092.2
Бусад эргэлтийн хөрөнгө	11,795,941.4	17,066,351.5	5,270,410.1
Үндсэн хөрөнгө	6,605,771.6	5,982,746.6	(623,025.0)
Нийт хөрөнгө	46,897,166.8	58,829,469.9	11,932,303.1
Өр төлбөр	580.4	1,005,471.9	1,004,891.6
Засгийн газрын оруулсан капитал	3,881,171.8	3,881,171.8	-
Хуримтлагдсан үр дүн	42,247,709.6	53,905,594.1	11,657,884.4
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	767,705.1	37,232.2	(730,472.9)
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	46,897,166.8	58,829,469.9	11,932,303.1

Дараах дансны үлдэгдэлд материаллаг дүнтэй өөрчлөлтүүд гарсан байна. Үүнд:

- Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 1,005,472.9 мянган төгрөг нь ОББҮХ-ны төрийн сангийн барьцаа хөрөнгийн дансанд байршиж байна. Үлдэгдлийн 99.9 хувийг гэрээний дүнгийн 5 хувь болох барьцааны баталгаа эзэлж байна.
- Авлага дансны үлдэгдэлд 69,938.6 мянган төгрөгийн татаас санхүүжилтийн авлага, 307,349.2 мянган төгрөгийн байгууллагаас авах авлага нь Цэвэр агаар сангаас шилжиж ирсэн авлага байна.
- Урьдчилгаа дансны үлдэгдэл өссөн нь Орчны бохирдлыг бууруулах үндэсний хорооны 2019 оны 19/01 тогтоолд тусгасан агаар, орчны бохирдлыг бууруулахад зориулж хэрэгжүүлж байгаа ажлын урьдчилгаа санхүүжилтээс шалтгаалжээ.
- Тайлант онд бараа материал худалдан авсан 13,390,756.8 мянган, хандиваар 1,332,956.9 мянган, шилжиж ирсэн 375.6 мянган төгрөгөөр нэмэгдэж, зарцуулсан 1,459,516.6 мянган, шилжүүлсэн 213,500.7 мянган, бусад 16,979.9 мянган төгрөгөөр хасагдсан байна. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар бий болсон агаар орчны бохирдлыг бууруулах хөтөлбөрийн санхүүжилтээр бэлтгэсэн 11,795,941.4 мянган төгрөгийн бусад эргэлтийн хөрөнгө бүртгэлтэй байна.
- Тайлант онд үндсэн хөрөнгө төсвийн хөрөнгөөр бэлтгэсэн 193,202.4 мянган, шилжүүлэн авсан 23,705.1 мянган, үнэ төлбөргүй хандиваар ирсэн 911,750.3 мянган, бусад 3,400.0 мянган төгрөг, нийт 1,132,057.8 мянган төгрөгөөр нэмэгдэж, балансаас балансад шилжүүлсэн 1,058,004.0 мянган төгрөг, акталсан 703,089.6 мянган, нийт 1,761,093.6 мянган төгрөгөөр хасагдсан байна.
- Өр төлбөр данс нь гэрээгээр ажил гүйцэтгэсэн 18 аж ахуйн нэгж, байгууллагын гэрээт ажлын барьцааны баталгаа болох 5 хувь буюу нийт 1,005,471.9 төгрөгийн үлдэгдэлтэй байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны санхүүжилтийн эх үүсвэрийг 192,950,195.3 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна. Төсвийн төслийг бодитой төлөвлөөгүйгээс төсвийн захирагчийн хүргүүлсэн төслийг 109,429,889.3 мянган төгрөгөөр бууруулж 83,520,306.0 мянган төгрөгөөр баталсан байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсөв захирагчийн хэрэгжүүлэх 6 хөтөлбөр арга хэмжээг 83,520,306.0 мянган төгрөг санхүүжүүлэхээс гүйцэтгэл 80,143,157.5 мянган төгрөг буюу 95.9 хувь байна.

№	Хөтөлбөрийн нэр	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	Тусгай хамгаалалттай газар нутгийн хамгаалалт хөтөлбөр	30,000.00	29,340.00	660.00	97.8
2	Агаар орчны бохирдлыг бууруулах үндэсний хөтөлбөр	74,345,091.50	72,770,604.90	1,574,486.60	97.9
3	Цөлжилт газрын доройтлыг бууруулах хөтөлбөр	440,466.60	381,714.50	58,752.10	86.7
4	Хүрээлэн буй орчны бодлого удирдлага хөтөлбөр	5,321,260.40	4,345,866.40	975,394.00	81.7
5	Хүрээлэн буй орчны судалгаа шинжилгээ хөтөлбөр	18,118.00	1,280.00	16,838.00	7.1
6	Аялал жуулчлалын хөтөлбөр	3,365,369.50	2,614,351.70	751,017.80	77.7

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Агаар, орчны бохирдлыг бууруулах үндэсний хөтөлбөрийн “Гэр хорооллын 2 тарифт тоолууртай айл өрхийн шөнийн цагт хэрэглэсэн цахилгаан эрчим хүчний үнийг 50-100 хувь хөнгөлөх” гэж заасны дагуу Эрчим хүчний яамтай 15,853,100.0 мянган төгрөгийн дүн бүхий ОББҮХ/2021-22 тоот гэрээг байгуулан ажиллаж, Баруун, Алтай Улиастай, Төв, Зүүн, Өмнөд бүсийн нэгдсэн эрчим хүчинд холбогдсон гэр хорооллын 2 тарифт тоолууртай айл өрхийн хэрэглэсэн цахилгааны тарифт эрчим хүчний хөнгөлөлт үзүүлсэн.

Засгийн газрын 2021 оны 53 дугаар хуралдааны тэмдэглэлд заасны дагуу “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний арга хэмжээг зохион байгуулах ажил зохион байгуулсан.

3.8 Аудитын гол асуудал

Засгийн газрын Коронавируст халдвар цар тахлын үед айл өрх, аж ахуйн нэгж, байгууллагуудад дэмжлэг үзүүлэх зорилгоор баталсан 2020 оны 12 дугаар сарын 13-ны 211 дүгээр тогтоолын дагуу 21 аймаг, 9 дүүрэгт хог хаягдлын санхүүжилт 17,961,115.4 мянган төгрөгийг олгосон.

Мөн Агаар, орчны бохирдлыг бууруулах үндэсний хөтөлбөрийн “Гэр хорооллын айл өрхийг стандартын шаардлага хангасан сайжруулсан түлшээр хангах, сайжруулсан түлшний үйлдвэрлэлийг дэмжин түүхий нүүрсний хэрэглээг орлуулах” гэж заасны дагуу шаардлага хангасан сайжруулсан түлшний үйлдвэрлэлд дэмжлэг үзүүлэх зорилгоор Таван толгой түлш ХХК-тай нийт 27,412,200.0 мянган төгрөгийн дүн бүхий гэрээ байгуулж, санхүүжүүлсэн байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасны дагуу дараах байдлаар нийцлийн аудитын асуудлыг тайланд тусгасан болно.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага нь тус хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т тус тус тусгасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан дараах 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Шилэн дансны цахим хуудсанд байршуулбал зохих 151 мэдээллээс 13 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны тухай хуулиар хүлээсэн үүргээ хэрэгжүүлэх, зөрчлийг давтан гаргахгүй байх талаар зөвлөмж өгөв.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй байна гэж дүгнэлээ.

3.10 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар тогтоосон 1,139,268.7 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт, 4,504,651.9 мянган төгрөгийн 2 албан шаардлага, 2 зөвлөмжийн биелэлт 100 хувьтай байна.

Хүснэгт-4 Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмж, албан шаардлагын хэрэгжилт /мянган төгрөг/

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Албан шаардлага	2	4,504,651.9	2	4,504,651.9	-	-	100
Төлбөрийн акт	1	1,139,268.7	1	1,139,268.7	-	-	100
Зөвлөмж	2	12,600,812.6	2	12,600,812.6	-	-	100
Нийт дүн	5	18,244,733.2	5	18,244,733.2	-	-	-

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар ОББҮХ-ны санхүүгийн тайлангийн урьдчилгаа дансанд бүртгэлтэй өмнөх онуудад болон тайлант онд байгуулсан гэрээний хэрэгжилт, бусад эргэлтийн хөрөнгө дансанд бүртгэлтэй тоног төхөөрөмжийн хуваарилалт, гүйцэтгэл, бараа материалын орлого, зарлага, хэрэгжүүлж буй хөтөлбөрүүдийн гүйцэтгэл, санхүүжилтийг авч үзэх шаардлагатай гэж үзлээ. Хөтөлбөрийн 9,750,200.0 мянган төгрөгийн гэрээт ажлын урьдчилгаа санхүүжилтийн гүйцэтгэлийг хүлээн аваагүй, Авлигатай тэмцэх газарт шилжүүлсэн байна.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 21,079,366.2 мянган төгрөгийн 7 алдаа, зөрчил илэрснээс, 95,614.7 мянган төгрөгийн санхүүгийн тайлагналтай холбоотой 1 алдааг залруулж, 20,983,751.5 мянган төгрөгийн зөрчилд 4 албан шаардлага хүргүүлж, алдаа, зөрчлийг давтан гаргахгүй талаар 2 зөвлөмж өглөө.

Залруулагдаагүй 8 алдаа, зөрчлийн дүн 20,983,366.2 мянган төгрөг нь тогтоосон ерөнхий материаллаг байдал 888,329.8 мянган төгрөгөөс хэтэрсэн тул Хязгаарлалттай дүгнэлт өглөө.

4.1 Залруулсан алдаа

Үйл ажиллагааны орлогыг 93,462.0 мянган, нийт зарлагыг 2,152.7 мянган төгрөгөөр дутуу, илэрхийлснийг аудитын явцад залруулав.

4.2 Албан шаардлага

1. Тайлант онд 49,048.6 мянган төгрөгийн спортын арга хэмжээ зохион байгуулсан нь Засгийн газрын “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” 2021 оны 43 дугаар тогтоолыг бүрэн хэрэгжүүлээгүй байна.

Энэ нь Засгийн газрын 43 дугаар тогтоолын 1.6-д “Засгийн газрын шийдвэр гарснаас бусад баяр ёслол, тэмдэглэлт ой, урлагийн наадам, спортын уралдаан тэмцээн, салбарын өдөр, аялал зугаалга зэргийг зохион байгуулахгүй байх” гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй, санхүүгийн тайлангийн нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж, төсвийг үр ашигтай хэмнэлттэй байхаар төлөвлөн зарцуулах, зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардал, төсөл арга хэмжээг тэвчиж, үргүй зардал гаргахгүй байх албан шаардлага өгөх.

2. Он дамжсан 307,349.2 мянган төгрөгийн авлагыг барагдуулаагүй, тайлант онд 69,788.6 мянган төгрөгийн авлага үүссэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д “төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх” гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Он дамжсан авлагыг барагдуулах арга хэмжээ авах, нэмж авлага үүсгэхгүй байх талаар албан шаардлага өгөх.

3. Хэрэгжиж дууссан төсөл, арга хэмжээтэй холбоотой ажлын гэрээг дүгнээгүй 8,403,546.7 мянган төгрөг, Аялал жуулчлалын хөгжлийн төвд шилжүүлсэн 365,363.2 мянган төгрөгийн урьдчилгаа санхүүжилтийн үлдэгдэл бүртгэлтэй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.7 “Энэ хуулийн 43 дугаар зүйлд зааснаас бусад тохиолдолд төсвийн жил дуусахад төсвийн захирагчийн төсөв зарцуулах эрх нь дуусгавар болох бөгөөд төсвийн захирагчийн төсвийн зарцуулагдаагүй үлдэгдлийг тухайн шатны төсвийн ерөнхий дансанд татан төвлөрүүлнэ”, Иргэний хуулийн 206 дугаар зүйлд “гэрээний талууд гэрээний үүргийг тогтоосон газар, хугацаанд нь, зохих ёсоор, шударгаар гүйцэтгэнэ” гэж заасныг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Хэрэгжиж дууссан төсөл, арга хэмжээний ажлын гэрээг дүгнэх, асуудлыг холбогдох байгууллагад тавьж шийдвэрлүүлэх арга хэмжээ авах албан шаардлага өгөх.

4. Улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл, хөтөлбөрийн үр дүнд бий болсон 11,795,550.6 мянган төгрөгийн өртөгтэй тоног төхөөрөмж, эд хөрөнгийг ашиглагч байгууллагуудад шилжүүлээгүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.7-д “хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавих, хүрэх үр дүнг хангаж ажиллах”, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолын 4.1.4-т “Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд улсын төсвийн хөрөнгө оруулалт, зээл, тусламж, хандиваар бий болсон хөрөнгийг үндсэн хөрөнгийн дансанд бүртгэхэд үнэ өртөг, эзэмших хуулийн этгээд нь тодорхойгүй болон маргаантай тохиолдолд Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт тавьж шийдвэрлүүлнэ” гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл, хөтөлбөрийн үр дүнд бий болсон тоног төхөөрөмж, эд хөрөнгийг ашиглагч байгууллагуудад шилжүүлэх асуудлаа өөрийн харьяалагдах дээд шатны төсвийн захирагчаар дамжуулан, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт тавьж шийдвэрлүүлэх талаар албан шаардлага өгөх.

4.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Үндсэн хөрөнгийн данстай холбоотой асуудал

Илрүүлэлт: Үндсэн хөрөнгийн хадгалалт, хамгаалалт болон санхүүгийн үйл ажиллагаанд тавих дотоод хяналт сул, анхан шатны баримтын бүрдэл хангалтгүй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийг 20.2 “Ерөнхий нягтлан бодогч дараах үүрэг хүлээнэ.”, 20.2.5-д “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах” гэсэн заалттай нийцээгүй байна.

Өгсөн зөвлөмж: Хөрөнгийн тооллого, хийж үлдэгдлийг баталгаажуулах, анхан шатны баримтын бүрдлийг хангаж ажиллах, зөрчлийг давтан гаргахгүй байх.

2. Бараа материалын данстай холбоотой асуудал

Илрүүлэлт: Бараа материалын орлого, зарцуулалтад тавих хяналтыг хэрэгжүүлж хэвшээгүй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийг 20.2 “Ерөнхий нягтлан бодогч дараах үүрэг хүлээнэ.”, “20.2.5-д “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах” гэсэн заалттай нийцээгүй байна.

Өгсөн зөвлөмж: Бараа материалын орлого, зарлагыг анхан шатны баримтыг хянан баталгаажуулж бүртгэлд тусгах, зөрчлийг давтан гаргахгүй байх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 9 дүгээр сарын 30 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Д/д	Байгууллагын нэр	Аудитын код	Алдаа зөрчлийн утга	Тогтоосон акт, албан шаардлага өгсөн зөвлөмжийн утга	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс					
							Залруулга		Албан шаардлага		Зөвлөмж	
					Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүүгийн тайлангийн аудитын асуудлаар												
1	Байгаль орчин, аялал жуулчлалын яам	АХГ-2022/11/НА-СТА-ТШЗ	Санхүүгийн тайланд 69,788.6 мянган, он дамжсан 307,349.2 мянган төгрөгийн авлага бүртгэлтэй байгаа нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх" гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.	Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх.	2	472,752.5	1	95,614.7	1	377,137.8		
2	Байгаль орчин, аялал жуулчлалын яам	АХГ-2022/11/НА-СТА-ТШЗ	Хэрэгжиж дууссан төсөл, арга хэмжээтэй холбогдон гарсан 8,403,546.7 мянган төгрөгийн зардлын үлдэгдэл урьдчилгаа дансанд бүртгэлтэй байна.	Хэрэгжиж дууссан төсөл, арга хэмжээний ажлын гэрээг дүгнэх, асуудлыг холбогдох байгууллагад тавьж шийдвэрлүүлэх	1	8,403,546.7			1	8,403,546.7		
3	Байгаль орчин, аялал жуулчлалын яам	АХГ-2022/11/НА-СТА-ТШЗ	Улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл, хөтөлбөрийн үр дүнд бий болсон 11,790,143.3 мянган төгрөгийн өртөгтэй тоног төхөөрөмж, эд хөрөнгийг ашиглагч байгууллагуудад шилжүүлээгүй байна.	Улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл, хөтөлбөрийн үр дүнд бий болсон тоног төхөөрөмж, эд хөрөнгийг ашиглагч байгууллагуудад шилжүүлэх	1	11,790,143.3			1	11,790,143.3		

Байгаль орчин, аялал жуулчлалын яамны 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

				асуудлаа өөрийн харьяалагдах дээд шатны төсвийн захирагчаар дамжуулан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт тавьж шийдвэрлүүлэх.								
4	Байгаль орчин, аялал жуулчлалын яам	АХГ-2022/11/НА-СТА-ТШЗ	Засгийн газрын 43 дугаар тогтоолыг зөрчин спортын арга хэмжээ зохион байгуулсан.	Төсвийн тухай хуулийн 10.1.7, 10.1.11-д заасныг тус тус үндэслэн төсөвт зардлыг хэмнэх, төсвийн хөрөнгийг үр ашигтай зарцуулах, төрөөс гаргасан тогтоол шийдвэрийг хэрэгжүүлж ажиллах.	1	49,048.6			1	49,048.6		
5	Байгаль орчин, аялал жуулчлалын яам	АХГ-2022/11/НА-СТА-ТШЗ	Үндсэн хөрөнгийн хадгалалт хамгаалалт болон санхүүгийн үйл ажиллагаанд тавих дотоод хяналт сул, анхан шатны баримт хангалтгүй байна.	Холбогдох хууль, тогтоомжид заасны дагуу тооллого хийж тооцоо бодох, Анхан шатны баримтын бүрдлийг хангаж ажиллах.	1	-					1	
6	Байгаль орчин, аялал жуулчлалын яам	АХГ-2022/11/НА-СТА-ТШЗ	Бараа материалын орлого, зардалд Төсөв захирагч, ерөнхий нягтлан бодогч хяналт хэрэгжүүлж хэвшээгүй.	Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг хэрэгжүүлж ажиллах, ажил гүйлгээг гарахаас өмнө хянан	1	-					1	

Байгаль орчин, аялал жуулчлалын яамны 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн
гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

				баталгаажуулж байх.								
7	Байгаль орчин, аялал жуулчлалын яам	АХГ-2022/11/НА-СТА-ТШЗ	Аялал жуулчлалын хөгжлийн төвтэй холбоотой 363,875.1 мянган төгрөгийн ажил хийгдсэн боловч 2019 оноос хойш урьдчилж гарсан зардал дансанд бүртгэлтэй байна.	Хэрэгжиж дууссан төсөл, арга хэмжээний ажлын гэрээг дүгнэх, асуудлыг холбогдох байгууллагад тавьж шийдвэрлүүлэх	1	363,875.1			1	363,875.1		
ДҮН					8	21,079,366.2	1	95,614.7	5	20,983,751.5	2	-
Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал												
1	Байгаль орчин, аялал жуулчлалын яам	АХГ-2022/11/НА-СТА-ТШЗ	Шилэн дансны цахим хуудсанд байршуулбал зохих 151 мэдээллээс 13 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.	Шилэн дансны тухай хуулиар хүлээсэн үүргээ хэрэгжүүлэх.	1	-					1	
ДҮН					1	-	0	-	0	-	1	-
НИЙТ ДҮН					9	21,079,366.2	1	95,614.7	5	20,983,751.5	3	-



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 02 дугаар сарын 05 № 157/00140054
ХТ-СЭЭЭ/Н/НН-СТБ-ТНБ

Улаанбаатар хот

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу хийсэн Байгаль орчин, аялал жуулчлалын яамны 2021 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:


Он дамжсан 307,349,228.26 төгрөгийн авлагыг барагдуулаагүй, тайлант онд 69,938.571.00 төгрөгийн авлага үүссэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх" гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-т заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Он дамжсан авлагыг барагдуулах арга хэмжээ авах, нэмж авлага үүсгэхгүй байх, албан шаардлагын биелэлтийг 2022 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Байгаль орчин, аялал жуулчлалын яамны Төрийн нарийн бичгийн дарга Э.Баттулга, Санхүү хөрөнгө оруулалтын үйлдвэрлэлийн хэлтсийн дарга М.Энх-Амар, нягтлан бодогч Д.Гантуяа нарт хариуцуулав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:
АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ
Г.ГҮНЖИДМАА
Г.МӨНХЧИМЭГ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 02 дугаар сарын 05 № 157/40170094
001 - 2022/11/14 - 001 - 413

Улаанбаатар хот

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу хийсэн Байгаль орчин, аялал жуулчлалын яамны 2021 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл, хөтөлбөрийн үр дүнд бий болсон 11,795,550,573.60 төгрөгийн өртөгтэй тоног төхөөрөмж, эд хөрөнгийг ашиглагч байгууллагуудад шилжүүлээгүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.7 "хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавих, хүрэх үр дүнг хангаж ажиллах", Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолын 4.1.4 "Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд улсын төсвийн хөрөнгө оруулалт, зээл, тусламж, хандиваар бий болсон хөрөнгийг үндсэн хөрөнгийн дансанд бүртгэхэд үнэ өртөг, эзэмших хуулийн этгээд нь тодорхойгүй болон маргаантай тохиолдолд Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт тавьж шийдвэрлүүлнэ" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгаагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-т заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл, хөтөлбөрийн үр дүнд бий болсон тоног төхөөрөмж, эд хөрөнгийг ашиглагч байгууллагуудад шилжүүлэх асуудлаа өөрийн харьяалагдах дээд шатны төсвийн захирагчаар дамжуулан, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт тавьж шийдвэрлүүлэх, албан шаардлагын биелэлтийг 2022 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Байгаль орчин, аялал жуулчлалын яамны Төрийн нарийн бичгийн дарга Э.Баттулга, Санхүү, хөрөнгө оруулалт, үйлдвэрлэлийн хэлтсийн дарга М.Энх-Амар, нягтлан бодогч Д.Гантуяа нарт хариуцуулав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ
Г.ГҮНЖИДМАА
Г.МӨНХЧИМЭГ

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр,
Утас 51-264230 9019120396

\\010.10.2\Bichig\Khereg\Alban Shaardlaga\2022\0225 Aудитын 2 Газар-153.Docx

0010800551



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 02 дугаар сарын 25 № 153/УОТ/ООФ/У
841 - 2022/11/11/М - СД - 749

Улаанбаатар хот

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу хийсэн Байгаль орчин, аялал жуулчлалын яамны 2021 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант онд спортын арга хэмжээнд 49,048,600.00 төгрөгийг зарцуулсан байна


Энэ нь Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын 1.6 "Засгийн газрын шийдвэр гарснаас бусад баяр ёслол, тэмдэглэлт ой, урлагийн наадам, спортын уралдаан тэмцээн, салбарын өдөр, аялал зугаалга зэргийг зохион байгуулахгүй байх" гэж заасныг хэрэгжүүлээгүй санхүүгийн тайлангийн нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-т заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж, төсвийг үр ашигтай хэмнэлттэй байхаар төлөвлөн зарцуулах, зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардал, төсөл арга хэмжээг төвчиж, үргүй зардал гаргахгүй байхад анхаарч, албан шаардлагын биелэлтийг 2022 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Байгаль орчин, аялал жуулчлалын яамны Төрийн нарийн бичгийн дарга Э.Баттулга, Санхүү, хөрөнгө оруулалт, үйлдвэрлэлийн хэлтсийн дарга М.Энх-Амар, нягтлан бодогч Д.Гантуяа нарт хариуцуулав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ
Г.ГҮНЖИДМАА
Г.МӨНХЧИМЭГ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

᠒᠐᠒᠒ оны ᠐᠘ дугаар сарын ᠒5 № 156/᠒᠐᠒᠒᠐᠐᠒4
᠑᠒᠑-᠒᠐᠒᠒/11/1᠕᠕ -᠒᠒᠔-᠐᠒᠑5

Улаанбаатар хот

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу хийсэн Байгаль орчин, аялал жуулчлалын яамны 2021 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Хэрэгжиж дууссан төсөл, арга хэмжээтэй холбоотой ажлын гэрээг дүгнээгүй 8,403,546,650.91 төгрөг, Аялал жуулчлалын хөгжлийн төвд шилжүүлсэн 365,363,210.65 төгрөгийн урьдчилгаа санхүүжилтийн үлдэгдэл бүртгэлтэй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.7 “Энэ хуулийн 43 дугаар зүйлд зааснаас бусад тохиолдолд төсвийн жил дуусахад төсвийн захирагчийн төсөв зарцуулах эрх нь дуусгавар болох бөгөөд төсвийн захирагчийн төсвийн зарцуулагдаагүй үлдэгдлийг тухайн шатны төсвийн ерөнхий дансанд татан төвлөрүүлнэ”, Иргэний хуулийн 206 дугаар зүйлд “гэрээний талууд гэрээний үүргийг тогтоосон газар, хугацаанд нь, зохих ёсоор, шударгаар гүйцэтгэнэ” гэж заасныг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө”, Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1-т заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Хэрэгжиж дууссан төсөл, арга хэмжээний ажлын гэрээг дүгнэх, асуудлыг холбогдох байгууллагад тавьж шийдвэрлүүлэх арга хэмжээ авах, албан шаардлагын биелэлтийг 2022 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Байгаль орчин, аялал жуулчлалын яамны Төрийн нарийн бичгийн дарга Э.Баттулга, Санхүү, хөрөнгө оруулалт, үйлдвэрлэлийн хэлтсийн дарга М.Энх-Амар, нягтлан бодогч Д.Гантуяа нарт хариуцуулав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:
АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АУДИТОР

(Handwritten signatures)

Ц.НАРАНЧИМЭГ
Г.ГҮНЖИДМАА
Г.МӨНХЧИМЭГ

